**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН**
**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН**
**2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**
**АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**
**(2022 оны 01 дүгээр улирлын байдлаар)**

2022 оны 03 дугаар сарын 10 — Багануур дүүрэг

| № | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ | Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Он | Түвшин | | | |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновац | | | | | | | |
| 3.2. Хотыг үйлдвэрлэл, инновацын төв болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ. | | | | | | | |
| 3.2.2 | Зорилт 3.2.2. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг үе шаттайгаар байгуулна. | Улс, нийслэлийн төсөв, төр хувийн хэвшлийн түншлэл | 2021 он | БҮТП-ийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, гадна инженерийн шугам сүлжээний батлагдсан зураг төсөлтэй. | БҮТП-ийн ерөнхий цахилгаан 110кВ-ын өндөр хүчдэлийн 6,76 км урт агаарын шугамын ажлыг эхлүүлнэ. | - Паркийн цахилгаан хангамжийн батлагдсан зураг төслийн хүрээнд 2022 онд эхлэх Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110 кВ-ын 6,76 км урт өндөр хүчдэлийн агаарын шугамыг барих ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан. Үүнд:<br>- Дээрх асуудлаар хувийн хэвшлээс хамтран хөрөнгө оруулалт хийж байгаа МЕСЕС ХХК-тай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, 2020 оны 02 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан 20/02 тоот гэрээг дүгнэж, уг бүтээн байгуулалтыг эхлүүлэх бэлтгэл ажил болон хөрөнгө оруулалтын талаар хэлэлцсэн. | “Үр дүнтэй” - 100% |
| 3.2.2.2 | Арга хэмжээ 3.2.2.2. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийг байгуулна. | 1,174.1 | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - МЕСЕС ХХК-тай хамтран хэрэгжүүлэх уг ажлын нийт 3,922.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 45%-ийг тус компаниас шийдвэрлэх ба хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт талаас уг ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>- Дээрх ажлын манай байгууллагаас оруулах санхүүжилтийн 2,174.1 сая төгрөгийг Нийслэлийн төсвөөс шийдвэрлэсэн бөгөөд 2022 оны төсөвт батлагдсан 1,171,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт зарлах бүх бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд:<br>- нийслэлийн барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч Б.Сүхбаатар дарга, НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан Ж.Эрдэнэчимэг Ахлах мэргэжилтэн, Худалдан авах ажиллагааны газрын Зураг төсөв хариуцсан Б.Амарболд мэргэжилтэн нартай уулзалт зохион байгуулж үүрэг чиглэл авч хамтран ажилласнаар нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан 1,174.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт НЗД-ын А/170 дугаар захирамжаар баталгаажсан.<br>- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийгдэх дээрх бүтээн байгуулалтад шаардлагатай материалыг нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 02 дугаар сарын 18- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ны өдрийн 17 дугаартай албан бичгээр болон amaraabasan24@gmail.com цахим хаягаар, нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 02 дугаар сарын 21-ний өдрийн 19 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>- Төсөвт тусгасан хөрөнгө оруулалтаар сонгон шалгаруулалт хуулийн хугацаанд зарлагдана.<br>**I улиралд тавьсан зорилт биелсэн тул гүйцэтгэлийн хувь-100** | |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГазар
УТГ0014 5184062
2715 109064

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНХЗАЯА